

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ПРОТОКОЛ**

2024 оны 04-р сарын 30-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцааны

- (i) 77 хувь буюу 7,996,539 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч “Хасвуу” ХХК;
- (ii) 18 хувь буюу 1,869,320 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч С.Нэргүй;
- (iii) 5 хувь буюу 519,256 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч Хас Энержи ПиТиЕэ Лтд (Khas Energy Pte Ltd) нар буюу хувьцаа эзэмшигчдийн 100 хувь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн байна.

Компанийн тухай хуулийн 83.8-д заасны дагуу Хасвуу ХХК-г итгэмжлэлгүй төлөөлөх этгээд нь түүний гүйцэтгэх захирал С.Нэргүй болох нь тус компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр нотлогдож байгааг;

иргэн С.Нэргүй нь тус хуралд өөрийн биеэр ирсэн болохыг түүний Монгол Улсын иргэний үнэмлэхээр нотлогдож байгааг;

түүнчлэн эзэмшигч Хас Энержи ПиТиЕэ Лтд (Khas Energy Pte Ltd) -ийг төлөөлж, түүнийг үүсгэн байгуулагч ДСЦТС ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Хангай итгэмжлэлийн дагуу оролцож байгааг;

С.Нэргүй болон Ц.Хангай нар нь 2023 оны 05 дугаар сараас - 2024 оны 04 сарыг дуустал ДСЦТС ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байгааг;

тус тус тэмдэглэн

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ын ирц 100 хувьтай бүрдсэн болохыг Хурлын дарга болон Компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байна.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье.ЭЭХ

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Г.ВЭХБАТ

ГИШҮҮН

М.БАЯРМАНЛА

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 30-ны өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

Хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани”гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРБААТАР

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 30-ны өдөр

Дугаар 24/02

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани" гэх) -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 03/01 дугаар тогтоолын хавсралтаар батлан гаргасан дүгнэлтийг сайшаан баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРБААТАР

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 30

Дугаар 24/03

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн гишүүдийг сонгох
болон ТУЗ-ийн зардлын төсвийг
батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани"гэх) -ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.8.7 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгож баталсугай.

Хараат бус гишүүд: Н.Эрдэнэбат; Г.Бэхбат; Ц.Баярбаатар; Н.Монсор;
Ж.Дэргэрсайхан.

Ердийн гишүүд: Б.Эрдэнэбилэг; Т.Энхмэнд; С.Нэргүй; Ц.Хангай.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРБААТАР

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 30

Дугаар 24/04

Улаанбаатар хот

*Компанийн дүрмийн
шинэчилсэн найруулгыг батлах
тухай*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.9, 62 дугаар зүйлийн 62.1.1, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани"гэх) -ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.7.1 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд хуульд заасан журмын дагуу энэхүү тогтоолыг баталснаас хойш ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хангай), ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга М.Баярманла нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРБААТАР